



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 401

Улаанбаатар хот

Халдварт өвчин судлалын үндэсний
төвийн дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан бүтэц, дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг тус төв /Д.Нямхүү/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2008 оны 34 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

165
Эрүүл мэндийн сайдын
2013 оны 10 сарын 31 өдрийн
401 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Халдварт өвчин судлалын үндэсний төв /цаашид төв гэх/ нь Олон Улсын Эрүүл Мэндийн дүрэм /цаашид ОУЭМД гэх/-ийн зохицуулагч байгууллагын үүргийг гүйцэтгэн, эрүүл мэндийг дэмжих замаар хүн амыг халдварт өвчнөөс сэргийлэх, хамгаалах, халдварт өвчний тандалт судалгаа, оношилгоо эмчилгээний талаар бодлогын бичиг баримтыг боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийх, томуу, томуу төст өвчин, улаанбурхан, сүрьеэ, ДОХ/БЗДХ, нян судлалын лабораториудын чиглэлээр лавлагаа төвийн үүргийг гүйцэтгэх мэргэжлийн байгууллага юм.

1.2. Төв нь халдварт өвчний тархалтыг тандан судлах, халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг авах, оношилгоо эмчилгээ, тусламж үйлчилгээг олон улсын стандартын түвшинд хүргэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх, халдварт өвчний үүсгэгчийг лабораториар баталгаажуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

1.3. Төв нь байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байна.

1.4. Төв нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн Хууль, Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын дагуу явуулна.

1.5. Төв нь Улаанбаатар хотод өөрийн байранд байрлан үйл ажиллагаа явуулна. Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14 дугаар хороо, Нам Ян Жугийн гудамж.

1.6. Төвийн нэрийг англи хэл дээр "National Center for Communicable Diseases" гэж орчуулна.

1.7. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

2.1. Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Үйлчлүүлэгчийг дээдлэх;
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг сахих;
- Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;
- Тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах;
- Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдэд чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
- Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх;

2.2. **Төвийн эрхэм зорилго** - ОУЭМД, Халдварт өвчинтэй тэмцэх Ази Номхон далайн бүсийн стратегийн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, Шинжлэх Ухаан технологийн дэвшил, хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжигч байгууллага байна.

Гурав. Төвийн эрх, үүрэг

3.1. Төв нь дараах эрхтэй:

3.1.1. Халдварт өвчний асуудлаар улсын хэмжээнд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, стандарт, эмнэлзүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний нөөц, материаллаг бааз, төсвийг бүрдүүлж зохих хууль, тогтоомж, журам, дүрмийн дагуу захиран зарцуулах;

3.1.3. Олон улсын байгууллага болон хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор гэрээ хэлэлцээр, санамж бичгийг харилцан үзэглэх, судалгаа шинжилгээний ажлыг олон улсын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран явуулах, хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах;

3.1.4. Төв нь тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, хамгаалах хувцас хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал тавьж шийдвэрлүүлэх;

3.1.5. Төв нь хууль тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

3.1.6. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх;

3.2. Төв нь дараах үүрэгтэй:

3.2.1. Төв нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, төвийн хөгжлийн хөтөлбөр, байгууллагын дотоод журам зэргийг боловсруулж хэрэгжүүлэн ажиллах;

3.2.2. Төв нь өөрийн үйл ажиллагааны онцлогыг тусгасан эрсдэлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжүүлэх;

3.2.3. Шинэ вакцин нэвтрүүлэх төсөл, судалгааны арга аргачлалыг ДЭМБ-ын зөвлөхүүд, хамтран ажилладаг эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран боловсруулах, эрдмийн болон мэргэжлийн зөвлөл, ёс зүйн хороогоор хэлэлцүүлж батлуулах, нэвтрүүлэх;

3.2.4. Бусад эрүүл мэндийн байгууллагаас холбогдох журмын дагуу шилжүүлсэн өвчтөнд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, эмчилгээний зөвлөмж, дүгнэлт гаргах, үзүүлж буй тусламж үйлчилгээ, оношилгоо, лабораторийн шинжилгээнд чанарын хяналт тавих, урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

3.2.5. Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, тандалтын стандарт, эмчилгээний удирдамж, арга аргачлал боловсруулах;

3.2.6. Халдварт өвчний чиглэлээр төгсөлтийн дараах албан ба албан бус сургалт, эрүүл мэндийн бүх байгууллагуудад ажлын байрны болон зайн сургалт явуулах;

3.2.7. Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;

3.2.8. Халдварт өвчний чиглэлээр хүн ам болон зорилтот бүлгийн дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд холбогдох байгууллагуудыг оролцуулан арга зүйн удирдлагаар хангах хамтран ажиллах;

3.2.9. Хүн амын дундах халдварт өвчний тархалт, нас баралтыг судлах тандалтын тогтолцоог өргөжүүлэн, мэдээллийн сан бүрдүүлж төрийн захиргааны төв байгууллага, олон нийтийн мэдээллээр хангах;

3.2.10. Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;

3.2.11. Төв нь тусламж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, ирсэн санал гомдолд дүн шинжилгээ хийж, залруулах арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган ажиллах;

3.2.12. Төв нь тухайн чиглэлээрээ болон байгууллагын үйл ажиллагаанд олон улсын түвшний итгэмжлэл, баталгаажилтыг авах;

3.2.13. Төв нь санхүү төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит болон нотолгоонд тулгууралсан байдлыг хангаж, үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн хувьд үр ашигтайг нь сонгон санхүүжүүлдэг байх;

3.2.14. Төв нь ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;

3.2.15. Төв нь ажиллагсдын мэдлэг ур чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, сахилга хариуцлагын хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

3.2.16. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг;

Төв нь дараах чиглэлээр лавлагаа лабораторийн үүргийг гүйцэтгэнэ.

3.2.17. **Томуу:**

- ✓ Томуугийн вирусыг ялган дүйж, омгийг тодорхойлон баталгаажуулах;
- ✓ Томуугийн вирусын зарим омгууд ялангуяа тухайн жилийн вакцины омгийн эсрэг дархан ийлдэст бага таныцтай дүйгдсэн болон дэд хэв шинж тодорхойгүй омгууд болон шинэ вирусын омгийг ДЭМБ-ын Томуугийн Лавлагаа төвүүдэд илгээх;
- ✓ Томуугийн вирусын үүсгэгчээр орон нутгийн вирус судлалын лабораториудыг молекул-биологийн аргаар үндэсний гадаад хяналтад хамруулах;

3.2.18. **Сүрьеэ:**

- ✓ Аймаг дүүргүүдээс онош тодруулахаар ирүүлсэн шинжилгээнд нян судлал, молекул-биологийн шинжилгээгээр лавлагаа үйлчилгээ үзүүлэх, гадаад чанарын хяналтад хамруулах;

3.2.19. **Улаанбурхан:**

- ✓ Улаанбурхан, улаанууд, гахай хавдрын омгуудыг баталгаажуулах;
- ✓ Жил бүр ДЭМБ-ын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангах;

3.2.20. **БЗДХ, нян судлал:**

- ✓ Микробиологи болон нян судлал, ийлдэс судлал, молекул-биологийн шинжилгээгээр лавлагаа үйлчилгээ үзүүлэх;
- ✓ Аймаг, дүүргүүдийн лабораториудыг үе шаттайгаар магадлан итгэмжлэлд хамруулах;

Дөрөв.Төвийн бүтэц, зохион байгуулалт

4.1. Төвийн удирдлагын тогтолцоо нь Ерөнхий захирал болон түүний дэргэдэх Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөс бүрдэнэ.

4.2. Ерөнхий захирал нь халдварт өвчний тандалт, сэргийлэлт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эрдэм шинжилгээ, сургалт, стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирлууд болон захиргаа, мэргэжлийн удирдлагуудын бүрэлдэхүүнтэй Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг батална.

4.3. Төв нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, төслийн арга аргачлал, явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөл байгуулж, түүний дүрмийг Ерөнхий захирал батална.

4.4. Төвийн Ерөнхий захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.

4.5. Төв нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, халдвар хяналтын салбар зөвлөл, эмийн эмчилгээ, санал гомдлын болон бусад хороог байгуулж ажиллуулна.

Тав. Ерөнхий захирлын эрх, үүрэг

5.1. Төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

5.2. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр төвийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах;

5.3. Шууд харъяалагдах албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг батлан, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, гэрээг цуцлах;

5.4. Төвийн бүтэц, алба, тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, ойрын болон хэтийн хөгжлийн бизнес төлөвлөгөө, жилийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;

5.5. Дэд захирал, тасгийн эрхлэгч, албадын дарга нарыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх ба шинээр ажилд орогсдыг байгууллагын дотоод журмын дагуу сонгон шалгаруулах;

5.6. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид ажиллах;

5.7. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах;

5.8. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төвийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;

Зургаа. Төвийн санхүүжилт

Төвийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

6.1. Улсын төсөв

6.2. Эрүүл мэндийн даатгал

6.3. Үндсэн (төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого, үйлчлүүлэгчийн захиалгаар хийх урьдчилан сэргийлэх үзлэг) ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, хууль тогтоомжинд нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон ашиг, орлого гэх мэт)

6.4. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүнээс авсан хандив, тусламж

6.5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

6.6. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэрүүдээс бүрдэнэ.

Долоо. Гадаад, дотоод хамтын ажиллагаа

7.1. Төвийг гадаад, дотоод хамтын ажиллагаанд Ерөнхий захирал төлөөлнө.

7.2. Төвийн Ерөнхий захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

7.3. Төвийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг Ерөнхий захирал шийдвэрлэнэ.

7.4. Төв нь Төрийн захиргааны төв байгууллагын удирдлагууд, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

7.5. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

Найм. Төвийн дэд захирлуудын эрх, үүрэг

8.1. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт эрхэлсэн дэд захирал

8.1.1. Халдварт өвчний тандалт судалгаа, Дархлаажуулалт, ДОХ/БЗДХ-ын тандалт судалгаа, Нэгдсэн лаборатори, Сүрьеэгийн тандалт судалгаа, Мэдээлэл, мэдээллийн технологи, Хүн, мал эмнэлгийн талбарын тархвар судлалын албадын үйл ажиллагааг шууд удирдан зохион байгуулж ажиллах;

8.1.2. Олон Улсын эрүүл мэндийн дүрэм, шинэ ба сэргэж буй халдвартай тэмцэх Ази номхон далайн бүсийн стратегийг хэрэгжүүлэх, халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

8.1.3. Халдварт өвчний тандалтын стандартыг мөрдлөг болгон халдварт өвчин тархахаас сэргийлэх, тандах, тархалтыг хязгаарлах, өвчлөлийг бууруулах, орон нутгийг мэргэжил арга зүйгээр хангах, дархлаажуулалт бүхий зарим халдварт өвчнийг эрс бууруулах, устгах нөхцөлийг бүрдүүлэх;

8.1.4. Халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах тандалтын тогтолцоог бэхжүүлэх, үндсэн чадавхийг бүрдүүлэх;

8.1.5. Халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэх, идэвхитэй тандалт явуулах талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээ, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллээр хангах;

8.1.6. Дархлаажуулалтын үйл ажиллагааг бүхий л шатанд бэхжүүлж, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, аюулгүй, чанартай вакцинаар хүн амыг дархлаажуулах

8.1.7. Шинэ болон хавсарсан вакцинуудыг дархлаажуулалтанд нэвтрүүлэх;

8.1.8. Олон Улсын байгууллага 2 талын хамтын ажиллагааг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах;

8.1.9. Талбарын тархвар судлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тасралтгүй сургалт явуулах;

8.1.10. Бусад холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

8.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал

8.2.1. Сувилахуйн алба, Амбулатори, Клиникийн лаборатори, Онош зүй, Эмчилгээний тасгуудын үйл ажиллагааг шууд удирдан зохион байгуулж ажиллах;

8.2.2. Үйлчлүүлэгчдэд эелдэг хөнгөн шуурхай үйлчилж, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлэн эрт оновчтой оношлон стандартын дагуу эмчлэх, хянах;

8.2.3. Эмнэлгийн үйлчилгээг үйлчлүүлэгчдэд чанарын өндөр түвшинд үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх ажлыг зохион байгуулж, хяналт тавих;

- 8.2.4. Эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх.
- 8.2.5. Эмчилгээний стандартын мөрдөлтийг хангаж, эмчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх;
- 8.2.6. Эмчилгээ, үйлчилгээний эдийн засгийн үр ашигтай, үр нөлөөтэй шинэ аргыг нэвтрүүлэх;

8.3. Судалгаа, шинжилгээ, сургалт, мэдээлэл эрхэлсэн дэд захирал

- 8.3.1. Эмнэлгийн мэргэжилтний сургалт, хөгжил, Эрдэм шинжилгээний албадын үйл ажиллагааг шууд удирдан зохион байгуулж ажиллах;
- 8.3.2. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлын шинжлэх ухааны үндэслэлийг дээшлүүлэх;
- 8.3.3. Эмч, мэргэжилтний эрдэм шинжилгээ, судалгааны ажлын мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх;
- 8.3.4. ШУТ-ын төсөлт ажлуудын гүйцэтгэлийг хангуулах, удирдах, зохион байгуулах;
- 8.3.5. ШУТ-ын төсөл бичиж, тендерт орох ажлыг зохион байгуулах;
- 8.3.6. Төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах;
- 8.3.7. Гадаадын болон Олон улсын байгууллагуудтай хамтарсан эрдэм шинжилгээний хурал, уулзалтыг зохион байгуулах;

8.4. Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал

- 8.4.1. Хүний нөөц, Стратеги төлөвлөлт, эдийн засаг, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, Хангамж үйлчилгээ, инженер технологийн албадын үйл ажиллагааг шууд удирдан зохион байгуулж ажиллах;
- 8.4.2. Хүний нөөцийг хөгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцсэн хүний нөөцийг бүрдүүлэн, чадавхийг нэмэгдүүлж ажиллах;
- 8.4.3. Ажиллагсадыг ажилласан жил, мэргэжил ажлын гүйцэтгэлд тохирсон цалин, урамшуулал олгох;
- 8.4.4. Ажиллагсадын ажиллах орчин, нөхцлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх;
- 8.4.5. Байгууллагын ойрын болон хэтийн төлөв, стратегийг боловсруулж, хэрэгжилтэнд, хяналт тавьж ажиллах, эдийн засгийн өртгийн судалгаа хийж төсөвлөх, төлөвлөх ажлын бодит үндэслэлийг тооцоолох;
- 8.4.6. Монгол Улсын "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай" болон холбогдох хуулиудын заалтыг хэрэгжүүлж байгууллагын үндсэн үүрэг зорилтыг ханган биелүүлэхэд шаардагдах төсөв зохих, санхүүгийн эх үүсвэрийг хуримтлуулах, хуваарилан зарцуулах, хянах батлуулах, биелэлтэнд хяналт тавих, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрийн санхүүгийн онцлогт тохируулан боловсруулах;
- 8.4.7. Төлбөрт үйлчилгээний орлогыг төвлөрүүлэх, орлогын үйл явцад хяналт тавих;
- 8.4.8. Санхүүгийн балансад шинжилгээ хийж, байгууллагын үйл ажиллагааны тооцоог гаргах, мэдээлэх;
- 8.4.9. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг улам бэхжүүлж, эмч, мэргэжилтнүүдийг гадаадад сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулах;

Ес. Төвийн албадын ерөнхий чиг үүрэг

Төв нь тусламж үйлчилгээ үзүүлэх тасаг, нэгжүүдийн чиг үүргийг тодорхойлж, өөрийн онцлогт тохируулан бүтцийг зохион байгуулах ба албадын чиг үүргийг тодорхойлно.

171

9.1 Халдварт өвчний тандалт, судалгааны алба - Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт судлагааны үйл ажиллагаанд шинжилгээ ухааны дэвшилтэт технологийн ололтыг нэвтрүүлж, лабораторийн шинжилгээ, нотологоонд тулгуурлаж, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах, халдварт өвчний хөдлөлзүйг гаргаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх;

9.2 Дархлаажуулалтын алба – Улсын хэмжээнд дархлаажуулалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, вакцин төлөвлөлт, захиалга, зарцуулалт, хамралтын мэдээ мэдээллийг гаргах, вакциныг хадгалах тээвэрлэх, хүйтэн хэлхээний хэм хяналтыг хийх, аюулгүй дархлаажуулалтын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;

9.3 Сүрьеэгийн тандалт судалгааны алба - Сүрьеэ өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг улсын хэмжээнд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сүрьеэ өвчний тархалтын судалгаа, шинжилгээг хийж, өвчлөлийг бууруулах чиглэлээр бодлого боловсруулах, эмчилгээний дэмжлэгт хяналт, эмийн захиалга хийж, чанартай баталгаатай эмээр төв, орон нутгийн сүрьеэтэй тэмцэх байгууллагуудыг тасралтгүй хангах;

9.4 ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны алба - БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх, оношлох, эмчлэх, лавлагаа тусламж үзүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, халдварын тархалтыг тандан судлах, эмчилгээний үр дүнг эмнэлзүй болон лабораторийн аргаар хянах, эм, лабораторийн оношлуур, урвалж бодисын хэрэгцээг тодорхойлох;

9.5 Нэгдсэн лабораторийн алба - Аймаг, дүүргийн лабораторийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, заавар гарын авлага боловсруулах, лабораториор оношлох, эмчилгээний явцыг хянах, шинжилгээ хийх, лабораториудын чанарын гадаад хяналтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

9.6 Хүн, мал эмнэлгийн талбарын тархвар судлалын алба – “Нэг дэлхий- Нэг эрүүл мэнд” зарчмыг хэрэгжүүлэх, хүн, мал эмнэлгийн салбар хоорондын тархвар зүйн сургалтыг зохион байгуулах, голомтод хамтарсан тандалт, судалгаа хийх, эрдэм шинжилгээний бүтээл гаргах;

9.7 Чанарын алба - Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, эмчилгээ, оношилгоо, лабораторийн шинжилгээний чанарт хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах, үйлчлүүлэгсдэд ээлтэй орчин бүрдүүлэх;

9.8 Эмнэлгийн мэргэжилтний сургалт, хөгжлийн алба – Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний, стратегийг хэрэгжүүлэх, төгсөлтийн дараах албан болон албан бус сургалт, эмч, мэргэжилтнүүдийн ажлын байран дахь тасралтгүй сургалтыг зохион байгуулах;

9.9 Эрдэм шинжилгээ, судалгааны алба - Тухайн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил эрхлэх, судалгааны дүн, зөвлөмж боловсруулах, халдварт өвчний чиглэлээр олон улсад нэвтэрч буй анагаах ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах;

172

9.10 Мэдээлэл, мэдээллийн технологийн алба - Үндэсний түвшинд халдварт өвчний статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэх, мэдээлэх, дамжуулах, тайлагнах, мэдээллийн сан үүсгэх үйл ажиллагааг хариуцна. Мөн өөрийн харъяа байгууллага, нэгжүүдэд бүртгэл, мэдээллийн талаар сургалт хийх, бүртгэл мэдээллийн байдалд хяналт тавих, цахим бүртгэл, бодит мэдээллийг нэвтрүүлэх, алсын зайн анагаах ухааныг нэвтрүүлэх;

9.11 Стратеги төлөвлөлт, эдийн засгийн алба - Байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх болон урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлого шийдвэртэй нийцүүлэн боловсруулах, уг стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтыг бодитой тодорхойлох, байгууллагын хэмжээнд ирэх жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн болон үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авах, байгууллагын дотоод журам, эрсдэлийн үеийн журам, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дээрх асуудлуудаар байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах;

9.12 Хүний нөөцийн алба - Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгцээтэй ажлын байрыг олон нийтэд нээлттэй зарлах, сонгон шалгаруулалтаар мэргэжилтнүүдийг сонгон авч ажиллуулах, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, өөрийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах, ажилтны нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

9.13 Санхүү бүртгэлийн алба - Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж байгаа "Төсвийн хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад нийцсэн харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргахад ач холбогдолтой, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах байдлаар зохион байгуулна. Мөн санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах, тодруулах, бэлтгэх ажлыг зохион байгуулах, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

9.14 Сувилахуйн алба - Байгууллагын хэмжээнд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, шалган, зааварлах, гүйцэтгэлд хяналт тавих сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал халдвар хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэнд хяналт тавих, чанарыг тасралтгүй дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулан арга хэмжээ авч ажиллах;

9.15 Хангамж, үйлчилгээ, инженер технологийн алба - Байгууллагын барилга байшин, эд хогшил, автомашин, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээлэл, холбооны ханган хэвийн үйл ажиллагааг тогтвортой байлгах, засвар үйлчилгээг хийх, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх, гадаад, дотоод орчны тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх, эмнэлгийн ариутгал халдваргүйтэлийн үйл ажиллагаанд шинэ бодисууд, технологийг нэвтрүүлэх, байгууллагын аюулгүй байдлыг хангах;

123
9.16 Хяналт-шинжилгээ, дотоод аудитын алба - Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх, эрсдэлийн үнэлгээ хийх бэлэн байдлыг хангах, шаардлагатай үед байгууллагын тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ хийх, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийн талаар үнэлгээ хийх, хяналт шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, зөвлөмж гаргах, байгууллагаар гүйцэтгүүлэх аудитыг зохион байгуулах;

9.17 Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба - Байгууллагын хөгжил, эмчилгээ оношлогооны дэвшилтэт арга технологийн чиглэлээр гадаад харилцааг өргөжүүлэн олон улсын байгууллагатай хамтран ажиллах төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллах, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарт оролцох ажлыг зохион байгуулах, өөрийн оронд зохион байгуулах, түүнд холбогдох хүмүүсийг оролцуулах;


9.18 Эм зүйн тасаг - Эмзүйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмчилгээний өндөр идэвхтэй, чанарын баталгаатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, эмийн жор бичилт, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, нян эмэнд тэсвэржихээс урьдчилан сэргийлэх, шинэ эмийг эмчилгээнд нэвтрүүлэх, эмч мэргэжилтнүүдийг эмийн мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

Арав. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

10.1 Төвийн Ерөнхий захирлын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВӨӨС
ХОЛБОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МЭРГЭЖИЛ
АРГА ЗҮЙН УДИРДЛАГААР ХАНГАХ ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ

174



→ Мэргэжил арга зүйн шууд удирдлага
- - - - - Мэргэжил арга зүйн шууд бус удирдлага

Эрүүл мэндийн сайдын
2013 оны сарын өдрийн
..... дугаар тушаалын
2 дугаар хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ

